

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
(Хот байгуулалт, хөгжлийн газар)**

2022 оны 06 дугаар сарын 05

Улаанбаатар хот

ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Дугаар	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
							Зорилтот түвшин үр дүнгийн үзүүлэлт	Төсөв /сая төгрөг/	Төсвийн гүйцэтгэл /сая төгрөг/		
1	2	3	4	5	6	7	8			9	10
ЗУРГАА.НИЙСЛЭЛ БА БҮС ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО											
6.1. Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрлийг задалж орон сууц, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэн хот байгуулалтын үйл ажиллагаанд ухаалаг технологи нэвтрүүлнэ											
6.1.1. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.	6.1.1.2	Хот байгуулалтын баримт бичиг, зураг төсөл, ТЭЗҮ, мастер төлөвлөгөөг боловсруулж үе шаттай хэрэгжүүлнэ.	2021-2024	Нийслэлийн төсөв	1.353	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /конвенц/ боловсруулагдсан.	3 баримт бичиг боловсруулсан байна.	937.129.050	463,715,300	- Барилга, хот байгуулалтын Сайдын 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэлэлцүүлэн дэмжиж, Засгийн газарт өргөн барьж хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Тус шийдвэртэй холбогдуулан баримт материалын бүрдлийг хангуулан Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. - "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай" Улсын Их хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Барилга, хот байгуулалтын Сайд,	100

1	2	3	4	5	6	7	8			9	10	
										<p>Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулсан. УИХ-ын тогтоолын төсөлд тусгах саналыг Засгийн газрын 16 яамдаас авч дууссан. Засгийн газрын хуралдаанаар Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлж өгөх тухай албан бичгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл хүсэх тухай албан бичгийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яаманд тус тус хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр зөвшөөрөл ирсэн, Сангийн яамнаас 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр хөрөнгө оруулалтын тооцоо засварлах санал ирүүлсэн. Тус саналын дагуу хөрөнгө оруулалтын тооцоог засварлаж Барилга, хот байгуулалтын яаманд 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 01/02/378 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>- 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Барилга, хот байгуулалтын Сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 94/А/443 тоот тушаал захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж, ажлын хэсгээс "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний баримт бичигт Сонсголт хот", "Сэлбэ сэргэлт" төслийг уялдуулан, баяжилт хийж боловсруулах үүрэг даалгавар өгсөн. Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганаар батлуулахаар шийдвэрлэсэн</p>		
	6.1.1 .5	Хот төлөвлөлтийн	2021	-	-	-	-	-	-	-	<p>- Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд "Хот тосгоны төлөвлөлт,</p>	90

1	2	3	4	5	6	7	8		9	10	
		норм, дүрэмд заасан хүн амын тооцоот нягтралаас хэтэрсэн газрын судалгааг гаргаж Хүн ам, барилгажилтын нягтралыг хориглох бүсийг шинэчлэн тогтооно.								барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30.01.04-т заасан хүн амын тооцоот нягтрал 1 га газарт 460 хүн байх хязгаарыг давсан 6 дүүргийн 111 хэсгийн 1163 га газрын нягтралын судалгааг гаргаж, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 19 дүгээр хурлаар хэлэлцүүлсэн. Тус судалгааг үндэслэж хотын төвийн хэсгийн барилгажилтын нягтрал өндөртэй хэсэгт инженерийн болон нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж, нийтийн эзэмшлийн зам, талбай барихаас бусад зориулалтаар, шинээр газар эзэмших, ашиглах эрх, барилга байгууламж барих зөвшөөрөл олгохгүй байх шийдвэрийг 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хурлаар танилцуулж дэмжигдсэн. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, тогтоол гарахаар хүлээгдэж байна.	
	6.1.1.6	Гэр хорооллыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.	2022 2024	Нийслэлийн төсөв	120.0	Гэр хорооллыг хөгжүүлэх 1 стратеги төлөвлөгөө	Гэр хорооллыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө	-	-	- Улс, нийслэлийн 2022, 2023 оны төсөвт тусгуулахаар саналаа албан бичгээр хүргүүлсэн боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй. - Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгуулахаар 2023 оны 01/01/1324 дугаартай албан бичгээр санал хүргүүлсэн.	30
6.1.2. Төр захиргаа, мэдээлэл технологи, бизнес санхүү, соёл, боловсрол, шинжлэх ухаан,	6.1.2.1	"Яармаг" хотын шинэ төвийн ерөнхий төлөвлөгөөг /Нисэх, Яармаг орчмын орон сууцны хорооллын	2021	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт	358.5	-	-	-	-	Нисэх, Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/651 дүгээр захирамжийн дагуу "27 дугаар нэгж хороолол"-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах	30

1	2	3	4	5	6	7	8			9	10
худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв, олон нийтийн төвүүдийг байгуулж хотын хэт төвлөрлийг бууруулна.		ерөнхий төлөвлөгөөний тодотгол/ шинэчлэн боловсруулж, төлөвлөлтийн дагуу бүтээн байгуулалт хэрэгжих боломжийг бүрдүүлнэ.								ажилд захиалагчийн хяналт тавин ажиллаж байна. Тус ажлын дундын тайланг Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 35 дугаар хурлаар хэлэлцүүлж, төлөвлөлтийн шийдлийг дэмжсэн. Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын яам, нутгийн захиргааны холбогдох байгууллагуудын саналыг тусган эцэслэн боловсруулахаар шийдвэрлэсэн. 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр захиалагчийн хяналт тавих гэрээ дуусгавар болсон. 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөр “27 дугаар нэгж хороолол”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үргэлжлүүлэн боловсруулж батлуулах талаар хэлэлцсэн.	
	6.1.2 .5	Дарь-Эх олон нийтийн төвийн ТЭЗҮ барилгажилтын төсөв боловсруулна.	2023	Улсын төсөв	115. 01.5 00	1	барилгаж илтын төсөл боловсруулсан байна.	92,008,400	23,002,100	Эцсийн тайланг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 14 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Магадлалын нэгдсэн дүгнэлт хийлгэж, 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Барилга, хот байгуулалтын яамны Шинжлэх ухаан техник технологийн хурлаар хэлэлцүүлж, дахин хэлэлцүүлэхээр хойшлогдсон.	90

1	2	3	4	5	6	7	8		9	10	
3.1.3. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаанд ухаалаг технологийг нэвтрүүлж, нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн мэдээллийн санг өргөжүүлэн иргэд, олон нийтэд нээлттэй болгон, тэгш хүртээмжийг нэмэгдүүлнэ.	6.1.3.1	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар олгох, барилга барих үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй болгоно.	2022 2023	Нийслэлийн төсөв	-	-	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн системийн ажлын гүйцэтгэл 100 хувьд хүрсэн.	200.0	200,0	- Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/923, 2023 оны А/73 дугаар захирамжийн дагуу "Смарт дата" ХХК-тай байгуулсан гэрээнд Захиалагчийн хяналт тавин, дундын тайлангийн гүйцэтгэлийн үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. Мөн тус ажлын эцсийн тайланг Газрын Захиргааны зөвлөлийн 2023 оны 04 дүгээр хурлаар хэлэлцүүлэн ХБМХ-2023/06 дугаартай актаар хүлээн авч, гүйцэтгэлийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. eBarilga.ub.gov.mn геопорталыг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж, үйлчилгээний хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэн ажиллаж байна. - Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 08 дугаар хурлаар "Хот байгуулалтын цахим систем болон хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх Мэргэжлийн зөвлөлийн хурлыг олон нийтэд нээлттэй болгосон тухай" ажлыг танилцуулж, дэмжигдсэн.	100
	6.1.3.3	Нийслэлийн хаягийн мэдээллийн санг шинэчлэн Улсын хаягийн нэгдсэн системд бүрэн холбоно.	2022	Улсын төсөв	-	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг Улсын хаягийн нэгдсэн системд холбох ажлын гүйцэтгэл 20 хувьтай байна.	Хаягжуулалтын суурь судалгааг бүрэн хийсэн байна.	-	-	Тус ажлын дундын тайланг хүлээн авч, гүйцэтгэлийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. Ажлын даалгаварт тусгагдсаны дагуу Улсын хаягийн системтэй холболт хийх байсан боловч Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас шалтгаалж, 2023 оны 02 дугаар сараас эхлэн www.urban.gov.mn геопортал, Улсын хаягийн мэдээллийн системүүдтэй холбох туршилтыг 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр хүртэл хийж амжилттай дууссан. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь хаягийн суурь мэдээллийг шинэчлэх	90

1	2	3	4	5	6	7	8			9	10
										ажлыг зохион байгуулж байгаа ба уг ажлыг гүйцэтгэсний дараа Улсын хаягийн системтэй холбогдож ажиллах боломж бүрдэнэ.	
	6.1.3.4	Нийслэлийн хэмжээнд хаягжуулалтын суурь судалгааг хийнэ.	2022	Улсын төсөв		Хаягжуулалтын суурь судалгааны ажлын гүйцэтгэл 10 хувьтай байна.	-	-	-	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/205 дугаар тушаалаар дэд ажлын хэсэг байгуулагдаж, ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу "Гадна хаягийн тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу байршуулах, хаягжуулалтын суурь судалгаа, тооцоог гаргах" ажлыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтэс хариуцан ажиллахаар болсон.	100
	6.1.3.6	Нийслэлийн 9 дүүргийн суурьшлын бүсэд 1:1000-ны масштабтай байр зүйн зураг хийнэ. /суурьшилтай хэсэг/	2022-2024	Нийслэлийн төсөв	-	-	160 нэрлбэр	678,4	-	- Улс, нийслэлийн 2022, 2023 оны төсөвт тусгуулахаар саналаа албан бичгээр хүргүүлсэн боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй. Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгуулахаар 2023 оны 01/01/1324 дугаартай албан бичгээр санал хүргүүлсэн.	30
6.1.9.Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулна.	6.1.9.1	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих төслийг эрчимжүүлнэ.	2022-2024	Улс, нийслэлийн төсөв		1556 өрхийн 13 орон сууцны гадна инженерийн шугам сүлжээний угсралт хийгдсэн байна.	Шинээр 968 өрхийн орон сууц ад орох нөхцөл бүрдэнэ.	-	-	-Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгыг дахин төлөвлөж барилгажуулах төслийн хүрээнд нийт 25 багцын 72 барилгад дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах төслийн санал авах урилгыг нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газраас 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр нээлттэйгээр зарлан, 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр хүлээн авсан. Нийт 7 багцад 12 аж ахуйн нэгжээс төслийн санал ирсэн бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2022 оны	70

1	2	3	4	5	6	7	8			9	10
										<p>A/1460 дугаар захирамжаар байгуулагдсан Үнэлгээний хороо саналыг хүлээн авч 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр төслийн саналыг нээж, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулсан.</p> <p>Барилга, хот байгуулалтын Сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар батлагдсан "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам"-ын 4.7 дахь заалтыг үндэслэн үнэлгээний хорооны дүгнэлтээр хамгийн сайн үнэлэгдсэн 5 аж ахуй нэгж байгууллагыг төсөл хэрэгжүүлэгчээр батламжилж, төсөл хэрэгжүүлэх эрх олгох захирамж гаргуулах тухай Нийслэлийн Засаг даргад танилцуулж шийдвэрлэсэн. Шалгарсан төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжүүдийн төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Нийслэлийн Засаг даргаар батлуулахаар захирамжийн төсөл хүргүүлсэн. Нийслэлийн Засаг даргын 2023 оны A/258 дугаар захирамжаар төсөл хэрэгжүүлэх эрх авсан "Профессионалстрой" ХХК-ийн Архитектур төлөвлөлтийн даалгаврыг МХЗ2023/15-003 дугаартай шинэчлэн баталсан.</p>	

1	2	3	4	5	6	7	8		9	10	
			2021-2024	Улс, нийслэлийн төсөв		Гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулна	12 багцын гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулна	29,600.0	-	- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 65 дугаар тогтоолоор хөрөнгө шилжих 6 байршилд 3160.9 сая төгрөг, шинээр 2 байршилд 1936.1 сая төгрөг шийдвэрлэгдсэн бөгөөд Худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар захиалагчийн хяналт гүйцэтгэн ажиллаж байна. 2023 онд 13 төсөл арга хэмжээний инженерийн дэд бүтэц, шугам сүлжээнд 26,707,8 сая төгрөг шаардлагатай бөгөөд тус шугамын бүтээн байгуулалтын ажил хийгдсэнээр 2172 айлын орон сууцны барилгын эхний ээлжийн 117 өрхийн орон сууцны барилга ашиглалтад орох боломж бүрдэнэ.	30
	6.1.9.2	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгын судалгаа, загвар зураг төслийг боловсруулна.	2022-2024	Нийслэлийн төсөв		Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны 206 загвар зураг төсөл боловсруулна	33 загвар зураг төсөл боловсруулсан байна.	398,0	-	Улс, нийслэлийн 2023 оны төсөвт барилгын судалгаа, загвар зураг төсөл боловсруулах хөрөнгө шийдвэрлэгдээгүй.	30
6.1.11. Барилга байгууламжийг паспортжуулан, газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийж, хүчитгэлийн	6.1.11.1	2000 оноос өмнө баригдсан орон сууц болон олон нийтийн зориулалттай барилга, байгууламжийн бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн	2021-2024	Нийслэлийн төсөв		2000 оноос баригдсан 840 барилгад дүгнэлт гаргаж, паспортжуулсан.	144 барилгад дүгнэлт гаргаж, паспортжуулсан байна.	-	-	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2023 оны А/11 дүгээр захирамж, Газрын даргын 2023 оны А/11 дүгээр "Үнэлгээний хороо байгуулах тухай" тушаалын дагуу 18 барилгад газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ хийж, бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргах ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр худалдан авах ажиллагааны цахим	30

1	2	3	4	5	6	7	8		9	10
зураг боловсруулж, лаборатори байгуулна.		дүгнэлт гарган, паспортжуулах ажлыг үргэлжлүүлнэ.							системээр олон нийтэд нээлттэй тендерийг зарласан. Тендер шалгаруулалтыг 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулж зураг төслийн 1 компани тендерийн баримт бичгийг ирүүлсэн. Тус ирүүлсэн материалыг 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр үнэлгээний хороогоор хэлэлцэн "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх заалтын дагуу дээрх ажилд ирүүлсэн тендерийг шаардлагад нийцээгүй тендер гэж дүгнэн татгалзсан. Одоогоор дахин худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар ажиллаж байна.	
			2022	Нийслэлийн төсөв	Барилга, байгууламжийн бат бэх, найдваржилтын төлөв байдалд хэмжилт хийх 15 багаж ашиглаж байна.	Барилга, байгууламжийн бат бэх, найдваржилтыг хэмжих багаж тоног төхөөрөмжөөр ханган.	-	-	Гамшгийн эрсдэлийг бууруулах Нийслэлийн зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулсан боловч хөрөнгө шийдэгдээгүй.	30
	6.1.11.2	Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, олон нийтийн барилгын хүчитгэлийн зураг,	2022-2024	Нийслэлийн төсөв	5 барилгын хүчитгэлийн зураг боловсруулсан.	6 барилгын хүчитгэлийн зураг боловсруулсан байна.			- Монгол Улсын Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлэх төслийн 2 дугаар үе шатны ажил эхлэхтэй холбоотой 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Япон Улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагын төлөөлөлтэй уулзаж, барилга байгууламжийг хүчитгэх эрх зүйн орчин, бодлого, норм дүрэм, хүчитгэх үйл	90

1	2	3	4	5	6	7	8	9	10	
		стандартын шаардлага хангасан амины сууцны нэг маягийн загвар зургийг боловсруулна.							ажиллагаа, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх талаар санал солилцов. Тус уулзалтаар 5 барилгын хүчитгэлийн зураг боловсруулахаар болсон. Төсөл 2022-2026 онд хэрэгжинэ. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/554 дүгээр захирамжаар Гамшигт тэсвэртэй амины орон сууцны нэг маягийн 10 төрлийн загвар зураг боловсруулах ажилд 100 сая төгрөг батлагдсан. Нийслэлийн Худалдан, авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт зарлаж, "Эм Эм Инженеринг" ХХК шалгарч, 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр 96.3 сая төгрөгийн өртөг бүхий гэрээ байгуулсан. Эцсийн тайланг гэрээнд заасны дагуу 2023 оны 01 дүгээр сарын 23-ний өдөр хүлээн авах байсныг "Эм Эм Инженеринг" ХХК-ийн гэрээ сунгах хүсэлтийн дагуу сунгалтын гэрээнүүдийг байгуулан эцсийн тайланг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүлээлгэн өгч, 2 хийц бүтээц бүхий 10 төрлийн барилгын иж бүрэн зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, барилгын төсвүүдийн хамт хүлээн авсан.	
6.2. Монгол Улсын үндэсний түвшний хөгжлийн бодлоготой нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулж, хүн амын нутагшилт, суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлж бүс, орон нутгийн хөгжлийн уялдааг хангуулна										
6.2.1. Дагуул, хаяа хот, тосгодын хөгжлийг эрчимжүүлэн хотын төвлөрлийг сааруулна.	6.2.1.1	"Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл", "Бүсийн хөгжлийн хөтөлбөр"-тэй Нийслэлийн	2021	-		-	-	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл", "Бүсийн хөгжлийн хөтөлбөр"-ийг уялдуулан төлөвлөсөн бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 35 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдэн Улсын Их Хурлын ээлжит	100	

1	2	3	4	5	6	7	8		9	10	
		хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулна.							хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.		
	6.2.1.2	Улаанбаатар хотын дагуул, хаяа хот, тосгодын төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.	2022	Нийслэлийн төсөв			Улаанбаатар хотын Жаргалант, Рашаант, 361-ийн гарам дагуул тосгодын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулсан байна.	-	-	Хөрөнгө оруулалтын ажил шийдэгдээгүйн улмаас тус ажил хийгдэх нөхцөл бүрдээгүй байна. Улс, Нийслэлийн 2024 оны төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн.	30
	6.2.1.3	"Шинэ Зуунмод", "Майдар" шинэ дагуул хотын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийн цэст өөрчлөлт оруулж, эхний ээлжийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлнэ.	2021-2024	-			"Шинэ Зуунмод", "Майдар" шинэ дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгуулах 1 санал боловсруулсан байна.	-	-	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд "Шинэ Зуунмод" хот, "Майдар" хотуудын тэргүүлэх чиглэлийг тусгасан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Улсын Их хуралд өргөн барихаар ажиллаж байна. "Шинэ Зуунмод" хот, "Майдар" хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, бүтээн байгуулалтын хэрэгжилт чиг үүргийн дагуу Барилга, хот байгуулалтын яам хариуцан ажиллаж байна.	100

1	2	3	4	5	6	7	8		9	10	
			2022	-			"Шинэ Зуунмод", "Майдар" шинэ дагуул хотын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийн цэст өөрчлөлт	-	-	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд "Шинэ Зуунмод" хот, "Майдар" хотуудын тэргүүлэх чиглэлийг тусгасан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их хуралд өргөн барихаар ажиллаж байна. "Шинэ Зуунмод" хот, "Майдар" хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, бүтээн байгуулалтын хэрэгжилт чиг үүргийн дагуу Барилга, хот байгуулалтын яам хариуцан ажиллаж байна.	100
	6.2.1.4	Богд уулыг тойрсон "Хөгжлийн алтан тойрог" байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна.	2022	Улсын төсөв	500.0	-	Богд уулыг тойрсон "Хөгжлийн алтан тойрог" байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг	-	-	Хөрөнгө оруулалтын ажил шийдэгдээгүйн улмаас тус ажил хийгдэх нөхцөл бүрдээгүй байна. Улс, Нийслэлийн 2024 оны төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн.	30
	6.2.1.5	Улаанбаатар хотын дагуул хотуудыг түшиглэн ачаа тээврийн логистик төв байгуулах техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.	2022	Нийслэлийн төсөв	500.0	-	Ачаа тээврийн логистик төв байгуулах техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулсан байна.	-	-	Хөрөнгө оруулалтын ажил шийдэгдээгүйн улмаас тус ажил хийгдэх нөхцөл бүрдээгүй байна. Улс, Нийслэлийн 2024 оны төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн.	30

1	2	3	4	5	6	7	8			9	10
	6.2.1 .6	“Барилгын материалын бөөний худалдааны төв”-ийн техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.	2021	Улсын төсөв		201.0	-	-	-	Улс Нийслэлийн 2022, 2023 оны төсөвт тусгуулахаар саналаа албан бичгээр хүргүүлсэн боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй. Улс, Нийслэлийн 2024 оны төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн.	30
	6.2.1 .7	Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлж эхэлнэ.	2022	Нийслэлийн төсөв		120.0	Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх бодлого боловсруулсан байна.			Улс Нийслэлийн 2022, 2023 оны төсөвт тусгуулахаар саналаа албан бичгээр хүргүүлсэн боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй. Улс, Нийслэлийн 2024 оны төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн.	30
	6.2.1 .8	Зарим Их, дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар төрөлжүүлж, дагуул хотуудад шилжүүлэх бодлого боловсруулж,	2021	-	-	Алсын хараа-2050 МУ-ын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан.	-	-	-	Хөрөнгө оруулалтын ажил шийдэгдээгүйн улмаас тус ажил хийгдэх нөхцөл бүрдээгүй байна. Улс, Нийслэлийн 2024 оны төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн.	30

1	2	3	4	5	6	7	8			9	10	
		хэрэгжүүлж эхэлнэ.										
	6.2.1.9	Төв аймагтай хамтран ажиллах эдийн засаг болон нийгмийн хөгжлийн чиглэлийг тодорхойлж, хамтын ажиллагааг нэмэгдүүлсэн байна.	2021	-		-	Хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулсан байна.	-	-	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хариуцан ажиллаж байна.	100	
6.3. Улаанбаатар хотын хөгжлийг хангасан, стандартад нийцсэн инженерийн дэд бүтцийг хөгжүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.												
6.3.21.Голуудын эрэг болон үерийн хамгаалалтын далан, суваг, шугам сүлжээг шинээр барих болон өргөтгөн шинэчилнэ.	6.3.21.1	Улиастай голын эргийн хамгаалалтын барилга байгууламжийг ашиглалтад оруулна.	2022 2024	Улсын төсөв		-	Зураг төсөл бэлэн болно.	1,600.0	-	- Хан-Уул дүүргийн 8, 21 дүгээр хорооны Жаргалантын амны үерийн хамгаалалтын сувгийн зураг төсөл боловсруулах даалгаврыг Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 03 дугаар хурлаар хэлэлцүүлэн баталсан. Тус ажлын хүрээнд 1,8км үерийн хамгаалалтын далан сувгийн ажлын зураг төсөл зөвшилцөв. - Туул голын үерийн хамгаалалтын далан сувгийн засвар шинэчлэлтийн ажил хийгдэнэ. Ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 11 дүгээр хурлаар хэлэлцүүлэн батлав. Ажлын зураг төслийн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч байгууллагаар "Хайдродизайн прожект" ХХК шалгарсан. 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн санал зөвлөмжийг хүргүүлсэн.	90	

1	2	3	4	5	6	7	8			9	10
6.3.24. Ус хангамжийн усан сан. Шугам сүлжээг шинээр барина.	6.3.24.1	Хужирбулан, Толгойт, Их наран, Буянт ухаа 2 хороололд шинээр усан сан, шугам сүлжээ барьж ашиглалтад оруулна.	2022-2023	Гадаад зээл		-	Зураг төсөл бэлэн болно.	-	-	Улс, нийслэлийн 2022, 2023 оны төсөвт тусгуулахаар саналаа албан бичгээр хүргүүлсэн боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй.	30
			2021-2024	Улсын төсөв		-	Буянт-Ухаа 2 хороолол орчимд усан сан, шугам сүлжээ барих ажлын гүйцэтгэл 30 хувьд хвэсэн байна.	-	-	- "Буянт Ухаа-2" хорооллын 2 дугаар ээлжийн Солонго-1,2 төслийн ус хангамжийн шугам сүлжээний зураг төслийг зөвшилцөв. - "Залуус-2" төслийн усан сан шугам сүлжээний ажлын зураг төсөл хийгдсэн.	100
			2021-2024	Улсын төсөв		-	Толгойт, Их наран орчимд усан сан, шугам сүлжээ барьж ашиглалтад оруулсан байна	1,100,0	-	- "Хайдродизайн инноваци" ХХК Толгойтын усан сан, цэвэр ус, ариутгах татуургын шугам сүлжээний ажлын зураг төслийг хийж гүйцэтгэсэн. - СХД-ийн 4-р хороо, Их Нарангийн авто зам дагуу Баянхошуу коллектор хүртэл хийгдэх ариутгах татуургын ф300мм - ийн 2,8 км шугамын барилга угсралтын ажил хийгдсэн. - Их Нарангийн усан сан, ус хангамжийн шугам сүлжээний барилга угсралт хийгдэж байна. - Буянт-Ухаа-2 хорооллын 2 дугаар ээлжийн төслийн ариутгах татуургын шугамын 1,3 дугаар ээлжийн ажлын зураг төсөл ф500/ф600 мм-ийн 2.1 км шугамын ажлын зураг төсөл зөвшилцсөн. - Сонгинохайрхан дүүргийн 2, 3, 26, 35, 36-р хороо, Толгойт, Их Нарангийн гэр хорооллын ус хангамжийн шугам сүлжээ, усан сан, насос станцын ажлын зураг төслийг баталгаажуулав.	100

1	2	3	4	5	6	7	8		9	10	
			20212024	Улс, нийслэлийн төсөв		Ус хангамжийн 586 км шугам сүлжээ байна.	Ус хангамжийн 3.9 км шугам сүлжээ барьж, ашиглалтад оруулсан байна.	-	-	Иргэн, хуулийн этгээдийн 121 байршилд ус хангамж, ариутгах татуургын ажлын зураг төслийг зөвшилцсөн.	100
	6.3.24.2	Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг шинээр барьж ашиглалтад оруулна.	2022	Улсын төсөв		Ариутгах татуургын 236 км шугам сүлжээ байна.	Ариутгах татуургын 9 км шугам сүлжээ барьж, ашиглалтад оруулсан байна.	3,190.0	-	Улсын төсвийн хөрөнгөөр: ✓ Сонгинохайрхан дүүргийн 4 хороо Их Нарангийн авто зам дагуу Баянхошуу коллектор хүртэл хийгдэх ариутгах татуургын ф400мм ийн 2,8 км шугамын барилга угсралтын ажил хийгдсэн. Ажлын зураг төсөл зөвшилцсөн. ✓ Буянт-Ухаа-2 хорооллын 2 дугаар ээлжийн төслийн ариутгах татуургын шугамын 1,3 дугаар ээлжийн ажлын зураг төсөл ф500/ф600 мм-ийн 2.1 км шугамын ажил хийгдсэн. Улсын төсвийн хөрөнгөөр 1,3-р үеийн ажлын зураг төсөл хийгдсэн. ✓ Сонгинохайрхан дүүргийн 2, 3, 26, 35, 36 хороо Толгойт, Их Нарангийн гэр хорооллын ус хангамжийн шугам сүлжээ, усан сан, насос станцын ажлын зураг төслийг баталгаажуулсан. Барилга угсралтын ажил хийгдэж байна. ✓ Залуус хорооллын ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний ажлын зураг төслийг "Монэнержи" ХХК гүйцэтгэж баталгаажуулсан. Шугамын барилга угсралтын ажил хийгдэж байна. ✓ Гандан хорооллын ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний	100

1	2	3	4	5	6	7	8			9	10	
											ажлын зураг төслийг "Кингсий инженер энд констракшн" ХХК баталгаажуулсан. Туул-1 бохир усны шугамын ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/474 дүгээр захирамжаар ажлын зургийн өөрчлөлт 110.0 сая төгрөг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/232 дугаар захирамжаар 3,4 дүгээр ээлжийн барилга угсралтын ажилд 3.190,2 тэр бум төгрөг батлагдсан. Туул-1 коллекторын трасст орсон иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжийн мэдээллийг гаргаж, ажлын зургийн өөрчлөлтөд тусгахаар ажиллаж байна. Шугам сүлжээний трасс олгосон газар чөлөөлөлтийг 2023 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд оруулахаар санал хүргүүлсэн.	
6.3.25.Одоо байгаа ус хангамжийн усан сан, шугам сүлжээг өргөтгөн шинэчилнэ.	6.3.25.1	Зүүн хойд бүсийн усан санг өргөтгөн шинэчилнэ.	2022-2024	ХБХГ			Зүүн хойд бүсийн усан сан 4,000 м3 эзлэхүүнтэй болгож өргөтгөж, шинэчилсэн байна.	-	-	Улс, Нийслэлийн 2022, 2023 оны төсөвт тусгуулахаар саналаа албан бичгээр хүргүүлсэн боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй.	30	
6.3.29.Цахилгааны шугам сүлжээг шинэчлэн, хүчин чадлыг нэмэгдүүлж, өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах нөхцөлийг	6.3.29.1	Хотын төв, гэр хороолол, зуслангийн бүсийн цахилгаан хангамжийн түгээх сүлжээг шинэчилж, шинээр хуваарилах	2021-2024	Улс, нийслэлийн төсөв		1,233 дэд өртөө, 60 дэд станц байна	110 дэд өртөө шинээр барьж, 2 дэд станц шинэчилсэн байна.	-	-	Улс, Нийслэлийн 2022, 2023 оны төсөвт тусгуулахаар саналаа албан бичгээр хүргүүлсэн боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй.	30	

1	2	3	4	5	6	7	8			9	10
бүрдүүлж, гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаан эрчим хүчээр бүрэн хангана.		байгууламж, дэд өртөө барина.									
	6.3.29.2	220/110 кВ-ын 2х125 МВА чадалтай Налайх транзит дэд станц барина.	2022-2024	Улс, нийслэлийн төсөв			Барилгын ажил 50 хувьд хүрсэн байна.	-	-	Улс, Нийслэлийн 2022, 2023 оны төсөвт тусгуулахаар саналаа албан бичгээр хүргүүлсэн боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй.	30
	6.3.29.3	Улаанбаатар дэд станцын хүчин чадлыг 2х200 МВА болгон тоноглож, шинэчилнэ.	2022-2024	Улс, нийслэлийн төсөв.			Барилгын ажил 50 хувьд хүрсэн байна.	-	-	Улс, Нийслэлийн 2022, 2023 оны төсөвт тусгуулахаар саналаа албан бичгээр хүргүүлсэн боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй.	30
	6.3.29.4	Ботаникийн цэцэрлэг, Баянхошуу, Их наран, Дамбадаржаа, ПРП нийт 5 иж бүрдэл 110/35/10 кВ-ын 2х40 МВА чадалтай дэд станц шинээр барих ажлыг эхлүүлнэ.	2022-2024	Улсын төсөв			4 дэд станцын барилгын ажил 40 хувьд хүрсэн байна.	-	-	Улс, Нийслэлийн 2022, 2023 оны төсөвт тусгуулахаар саналаа албан бичгээр хүргүүлсэн боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй.	30
	6.3.29.5	Бага тойрог 110 кВ-ын цахилгаан сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	2022-2024	Улсын төсөв			Шугамын ажил 80 хувьд хүрсэн байна.	-	-	Улс, Нийслэлийн 2022, 2023 оны төсөвт тусгуулахаар саналаа албан бичгээр хүргүүлсэн боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй.	30

1	2	3	4	5	6	7	8		9	10	
	6.3.29. 6	50 МВт.ц багтаамжтай цахилгаан цэнэг хураагуурын станц барина	2021-2024	Гадаа дын зээл		Цэнэг хураагуурын станц байхгүй	Барилгын ажлын гүйцэтгэл 20 хувьд хүрсэн байна.	-	-	80 МВт/200 МВт.ц чадалтай эрчим хүч хуримтлуулах зай хураагуурын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "ЗТТ" болон ZEST" компаниудын хамтарсан консорциумтай 2022 оны 07 дугаар сард ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Геодези болон Инженер-геологийн судалгааны ажлуудыг гүйцэтгэж дуусган, ажлын зураг төслийг боловсруулж байна.	30
	6.3.29. 7	Гэр хорооллын айл өрхүүдийг 4 кВт чадалтай цахилгаан халаагуур ашиглах боломжийг бүрдүүлнэ.	2021-2024	Улс, нийслэлийн төсөв.		4 кВт чадалтай цахилгаан халаагуур ашиглах боломжтой болсон 42,000 айл өрх байна.	16,000 айл өрхийг цахилгаан халаагуур хэрэглэх боломжтой болсон байна.	-	-	Гэр хорооллын айл өрхүүдийг 4 кВт чадалтай цахилгаан халаагуур ашиглах боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн 12 байршлын 3860 айлын ажлын зургийг 2022 онд зөвшилцсөн, 2023 онд 392 цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл зөвшилцсөн.	70
6.3.31. Дулааны станц шинээр барих, өртгөтгөх, технологийн шинэчлэл хийнэ.	6.3.31. 1	Налайх дүүрэг, Дамбадаржаа, Сэлбэ дэд төвийн дулааны станц шинээр барьж, ашиглалтад оруулна.	2022-2024	Улс, нийслэлийн төсөв.		Сэлбэ дэд төвийн дулааны станцын бүтээн байгуулалтын ажил 9 хувь	Барилгын ажил 30 хувьд хүрсэн байна.	-	-	- Сэлбэ дэд төвийн дулааны станц 2021 оны 4 дүгээр улиралд ашиглалтад орсон. Тус дулааны станцын 7МВт-ын халаалтын 1 зуух ажиллагаанд залгагдсан бөгөөд 29 аж ахуйн нэгж байгууллага төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбогдсон. - Налайх дүүрэг 180 МВт-ийн дулааны станцын ажлын зураг төсөл хийгдэж дууссан, 2023 оны улсын төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн. Дамбадаржаа дэд төвийн дулааны станцын ТЭЗҮ, ажлын зураг төсөл бүрэн дууссан. Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслөөр хэрэгжихээр газар чөлөөлөлтийн ажил бүрэн хийгдсэн.	100

1	2	3	4	5	6	7	8		9	10	
	6.3.31. 2	Амгалангийн дулааны станцыг 50 МВт-ын дулаан, цахилгаан хосолмол хүчин чадалтай болгож нэмэгдүүлнэ	2021-2024	Гадаадын зээл	120,000,0	-	Барилгын ажил 30 хувьд хүрсэн байна.	-	-	Амгалангийн дулааны станцын өргөтгөлийн ажлыг концессын гэрээгээр гүйцэтгэхээр Эрчим хүчний яам гэрээ байгуулан ажиллаж байна. 100Гкал/цагийн дулааны эх үүсвэрийн өргөтгөлийн барилгын суурийн цутгалт хийгдэж байна. 2024 онд ашиглалтад орох төлөвлөгөөтэй ажиллаж байна.	30
6.3.32. Дулааны гол магистраль шугамын дулаан нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлнэ.	6.3.32. 1	Төвлөрсөн дулаан хангамжийн системийн төв магистраль шугамуудыг өргөтгөх шинэчлэх ажлыг гүйцэтгэнэ.	2021-2023	Улс, нийслэлийн төсөв.	57,931,2	-	Угсралтын ажил 50 хувьд хүрсэн байна	-	-	- Улсын төсөв болон Европын сэргээн босголтын банкны санхүүжилтээр төвлөрсөн дулаан хангамжийн өргөтгөл шинэчлэлтийн 2ф200/350/400/500/700/800/1000мм-ийн голчтой 8.404км дулааны шугамын барилга угсралтын ажлыг хийхээр төлөвлөгдсөн. Сэлбэ дулааны станцаас хангагдах УДДТ-12, 1,2 км дулааны шугам сүлжээ ашиглалтад орсон. - ТЭЦ-3-аас холбогдсон 5 дугаар магистралийн өргөтгөл шинэчлэлийн ажил хийгдсэн.	100
	6.3.32. 2	Төвлөрсөн дулаан хангамжийн системийн шугам сүлжээг шинээр барьж нэмэгдүүлнэ.	2021-2024	Улс, нийслэлийн төсөв.	69,795,5	-	Угсралтын ажил 50 хувьд хүрсэн байна	14,000.0	ЕСББС	Улсын төсөв болон Европын сэргээн босголтын банкны санхүүжилтээр төвлөрсөн дулаан хангамжийн өргөтгөл шинэчлэлтийн 2ф600/400мм-ийн голчтой 1.8км дулааны шугамын барилга угсралтын ажлыг хийхээр төлөвлөгдсөн. Ажлын зураг төсөл зөвшилцсөн.	100
6.3.33. Хатуу түлшний халаалтын зуухнуудыг үе шаттайгаар төвлөрсөн дулаанд	6.3.33. 2	Хийн түлшний дулааны эх үүсвэрүүдийг барьж байгуулна.	2022-2024	Улсын төсөв.			Хийн түлшний 1 эх үүсвэр барьсан байна.	-	-	- Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2021 оны V дугаар хуралдааны 01 дүгээр хурлын тэмдэглэлээр Төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээтэй хосолмол ажиллагаатай 80 Гкал/цагийн хийн түлшний дулааны эх үүсвэрийн ТЭЗҮ	70

1	2	3	4	5	6	7	8	9	10
холбох, хийн түлшинд шилжүүлнэ.								<p>дэмжигдсэн. Тус станц нь Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны нутагт 3,8 га нэгж талбарт төлөвлөгдсөн бөгөөд одоогоор газар чөлөөлөлт хийгдээгүй байна. /Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба хариуцна./</p> <p>- Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1322 дугаар захирамжаар Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах бүсэд түүхий нүүрс хэрэглэдэг халаалтын зуухыг буулгаж төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлын хөрөнгө шийдвэрлэгдсэн. Уг ажлын барилга угсралтын ажил дуусаж, улсын комисст хүлээлгэн өгөх бүрэлдэхүүнд ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Хан-Уул дүүргийн 5 дугаар хороо, 41-р сургууль, 29, 71-р цэцэрлэгийн барилга ✓ Баянзүрх дүүргийн 10-р хороо, ШШГЕГ-ын харьяа 421-р нээлттэй хорих ангийг төвлөрсөн дулаан, хүйтэн ус ✓ Баянзүрх дүүргийн 8, 16, 19-р хороо, Газарчин, Эрдэнэ-Толгой орчмын уурын зуухтай 21 айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудыг төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбох; ✓ Сонгинохайрхан дүүргийн 2 дугаар хороонд байрлах 42 дугаар сургууль, 81 дүгээр цэцэрлэгийн барилга. <p>- Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн нэгжид Нийслэлийн СХД, СБД, БЗД-ийн 10 байршилд сургууль, цэцэрлэгийн барилгын халаалтын зуухыг шинэчлэн хийн түлш болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй хосолмол</p>	

1	2	3	4	5	6	7	8		9	10	
									<p>ажиллагаатай ажиллах ажлын зургийн даалгавар батлуулж хүргүүлсэн. Тус ажлуудын ажлын зураг төслийг зөвшилцсөн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ СХД-ийн 24 дүгээр хороо, 134-р сургууль ✓ СХД-ийн 28-р хороо, 640 хүүхдийн сургууль ✓ СХД-ийн 25-р хороо, 170-р цэцэрлэг ✓ СХД-ийн 25-р хороо, 104-р сургууль ✓ СХД-ийн 4-р хороо, 640 хүүхдийн сургууль ✓ СХД-ийн 11-р хороо, 129-р сургууль ✓ БЗД-ийн 11-р хороо, 79-р сургууль ✓ БЗД-ийн 11-р хороо, 126-р сургууль ✓ СБД-ийн 17-р хороо, 58-р сургууль <p>Нисэх, Яармаг орчмын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу хийн түлшний дулааны эх үүсвэр барих ТЭЗҮ боловсруулах зардлыг 2023 оны Улс, нийслэлийн төсөвт тусгуулахаар 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 02/01/1250 дугаар албан бичгээр саналаа хүргүүлэв.</p>		
6.3.34. Мэдээлэл холбооны электрон автомат телефон станц, мэдээлэл холбооны нэгдсэн төвийн барилгуудыг холбож, нэгдсэн том сүлжээ үүсгэн, зохион байгуулалтыг сайжруулна.	6.3.34.2	Сувагчлалын байгууламж шинээр барина.	2021-2024	Улс, нийслэлийн төсөв.	7.665,3	Сувагчлалын байгууламжийн урт 1.066 км	Сувагчлалын байгууламжийг 12 км-ээр нэмэгдүүлсэн байна.	-	-	<p>Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн хүрээнд Баянхошуу дэд төвийн мэдээлэл холбооны нэгдсэн төвийг холбосон 2,94 км худаг сувагчлал, Сэлбэ дэд төвийн мэдээлэл холбооны нэгдсэн төвийг холбосон 2,78 км худаг сувагчлал шилэн кабелийн сүлжээний барилга угсралтын ажил дуусаж улсын комисс ажиллан байнгын ашиглалтад оруулсан.</p> <p>- Морин давааны чиглэлд 4 км худаг сувагчлалын байгууламж 90 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.</p>	100

1	2	3	4	5	6	7	8	9	10
								- Нийт 9,72 км худаг сувагчлалын байгууламж барьсан.	

Нийт 45 арга хэмжээ, хэрэгжилтийн дундаж хувь 60 хувь байна.

ХЯНАСАН: ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

НЭГТГЭСЭН: МЭРГЭЖИЛТЭН

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН: МЭРГЭЖИЛТЭН

Ч.БАДАМХАНД

Б.АМАРБАЯСГАЛАН

Л.АДЪЯАСҮРЭН